

China Unicom (NYSE:CHU)

Компанийн танилцуулга

"China United Network Communications Group Co., Ltd." буюу "China Unicom" нь Хятад улсад үйл ажиллагаагаа явуулдаг Хятадын төрийн өмчит үүрэн болон суурин шугамын яриа, түүнтэй холбогдох нэмүү өртөг шингэсэн үйлчилгээ үзүүлэгч компани юм. China Unicom нь харилцагчийн тоогоороо дэлхийд 4-т бичигддэг том компани юм. 2019.12.31-ны байдлаар тус компани нь 254 сая 4G хэрэглэгч, 83 сая суурин шугамын broadband хэрэглэгч болон 54 сая дотоодын суурин шугамын ярианы хэрэглэгчтэй байсан байна.

1Q2020

"China Unicom" нь 2020 оны 1-р улиралд өмнөх оны тус үетэй харьцуулбал 2.3 хувийн орлогын өсөлт үзүүлсэн байна. Энэ нь COVID-19 вирус орлого буурахад нөлөөлсөн гэхэд тийм ч мүү үзүүлэлт биш юм. Гар утас хэрэглэгчдийн тоо 2-р сард огцом унасан ч 3-р сард өссөн байна. EBITDA болон орлогын дүн өмнөх жилийн тухайн үетэй харьцуулахад 6 хувь болон 14 хувь тус тус өссөн нь ерөнхий ба удирдлагын зардал өссөнтэй холбоотой гэж үзэж байна.

• Ковид-19 вирус гар утасны бизнест муугаар нөлөөлсөн ч суурин шугамын бизнест сайнаар нөлөөлсөн:

Гар утасны бизнесийн орлого өмнөх оны тус үетэй харьцуулбал 2019 оны 4-р улиралд 2.5 хувь, 2020 оны 1-р улиралд 4.1 хувь тус тус буурсан. Гар утасны дуудлагын тоо 22 хувь буурсан ч өргөн зурвасын интернет (broadband) болон үүлэн технологийн (cloud) эрэлт ихэссэнээр суурин шугамын ярианы орлого өмнөх оноос 11 хувь өссөн байна. Үйлдвэрлэлийн салбарын интернетийн орлого энэ оны 1-р улиралд өмнөх оны тус үетэй харьцуулахад 32 хувиар огцом өссөн байна. Нийт үйлчилгээний орлого энэ оны 1-р улиралд өмнөх онтой харьцуулахад 2.9 хувиар өссөн ба 2019 оны 4-р улиралтай харьцуулахад 3 хувь өссөн нь 1-р улирлын нөхцөл байдлыг авч үзэхэд тийм ч мүү үзүүлэлт биш юм. COVID-19 намжсанаар 2020 оны сүүл гэхэд үйлчилгээний орлогыг өснө гэж таамаглаж байна.

• Гар утас хэрэгдэгчдийн тоо 3-р сард үргэлжлүүлэн өссөн:

China Unicom-н шинээр гар утас хэрэглэгчдийн тоо 3-р сард 0.3 саяаар нэмэгдсэн байна. 2-р сард 6.6 сая хэрэглэгч алдсан нь голдуу хоёр дахь симийн ашиглалтыг цуцалсантай холбоотой мөн хүмүүс гэртээ байсны улмаас олон оператор дэлгүүрүүд хаагдаж шинэ хэрэглэгчид багассантай холбоотой юм. Хэдий 3-р сард шинэ хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн ч өсөлтийн тренд 2020 он дуустал өснө гэж таамаглахад нөхцөл байдал хэцүү байна.

• Нийт орлого болон EBITDA (зээлийн хүү, татвар, элэгдэл болон хорогдлоос өмнөх ашиг) буурахад G&A (ерөнхий болон удирдлагын) зардал өндөр гарсан нь нэгэн хүчин зүйл болжээ:

EBITDA-н өсөлт өнгөрсөн оны мөн үед жилийн -2.5 хувь байсан бол, 2019 оны 4-р улиралд -3.0 хувь болж, 2020 оны эхний улиралд -6.0 хувьд хүрсэн нь уг орлого хэрхэн хурдацтайгаар унаж байгааг харуулж байна. Орлогын хувь хэмжээ ийнхүү буурахад 1) COVID-19-с шалтгаалсан борлуулалтын орлогын нөлөөлөл, 2) маркетинг, борлуулалтын зардал хөл хорион арга хэмжээний улмаас жилийн 15 хувиар багассан ч ажилчдын халамжийн зардал 15 хувиар ихэссэн, мэдээлэл холбоо харилцааны технологийн бизнесийн хурдацтай өсөлттэй холбоотойгоор техникийн тусламжийн зардал давхар нэмэгдсэн, үл хөдлөх хөрөнгийн борлуулалт болон мүү өр зээлэн дээр ихээхэн хэмжээний алданги хүлээсэн зэргээс үүдэж ерөнхий болон захиргааны зардал жилийн 44 хувиар өсөж улмаар эдгээрийн орлогод үзүүлж буй нөлөөлөл цэвэр дүнгээрээ сөрөг гарсан 3) энэ улирлын санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулахаар зардала ханах сэдэл бага байгаа зэрэг нөлөөлсөн гэж бид үзэж байна.

5G сүлжээ нэвтрэлт

China Unicom нь 2019 оны 9-р сард China Telecom компанитай Хятад улсад 5G сүлжээг нэвтрүүлэх хамтын гэрээ байгуулсан билээ. Энэхүү гэрээний үндсэн дээр China Unicom нь 5G сүлжээ хамарч байгаа хүрээ, зурвасын өргөн (bandwidth), багтаамж болон дамжуулалтын хурдаа хоёр дахин нэмэгдүүлэх боломжтой болж байгаа юм. China Unicom болон China Telecom нь 50,000 5G сүлжээний суурь станцуудыг хувааж байгаа бөгөөд нийтдээ 10 тэрбум юаны хөрөнгө оруулалтын зардлыг хэмнэлт хийж чадсан байна. China Unicom нь 2019 оны байдлаар нийт 56.4 тэрбум юань хөрөнгийн зардал гаргасан бөгөөд үүнээс 7.9 тэрбумыг 5G сүлжээний хөгжүүлэлтэд зарцуулсан. Харин 2020 онд нийт 70 тэрбум юаныг төсөвлөөд байгаагаас талыг нь буюу 35 тэрбум юаныг 5G сүлжээний хөгжүүлэлтэд зарцуулахаар төлөвлөөд байгаа юм.

Эрсдэл, саад бэрхшээл:

- Зах зээлийн ханасан байдлаас үүсэж буй хүчтэй өрсөлдөөн, нэмэлт хурд, тарифын хасалтаас улбаалан гарч ирж буй сөрөг нөлөөлөл.
- 5G сүлжээний капиталын болон үйл ажиллагааны зардал нэмэгдсэнтэй холбоотой шинэ сорилтууд

Санхүүгийн үзүүлэлтүүд

Breakdown	FY2016	FY2017	FY2018	FY2019	FY2020A
Total Revenue	274,197,000	274,829,000	290,877,000	290,515,000	296,087,000
Cost of Revenue	133,042,000	119,972,000	121,769,000	107,108,000	100,298,994
Gross Profit	141,155,000	154,857,000	169,108,000	183,407,000	195,788,006
Operating Expenses	133,934,000	143,480,000	155,824,000	169,565,000	183,440,483
Operating Income or Loss	7,221,000	11,377,000	13,284,000	13,842,000	12,347,523
Interest Expense	4,908,000	5,237,000	1,567,000	2,016,000	2,037,312
Total Other Income/Expense Net	-2,320,000	-4,928,000	-210,000	1,137,000	1,142,586
Income Before Tax	784,000	2,593,000	13,081,000	14,167,000	15,100,437
Income Tax Expense	154,000	743,000	2,824,000	2,795,000	2,848,607
Income from Continuing Operations	630,000	1,850,000	10,257,000	11,372,000	12,251,830
Net Income	625,000	1,828,000	10,197,000	11,330,000	12,234,000
Net Income available to common shares	625,000	1,828,000	10,197,000	11,330,000	12,234,000
Basic EPS	0.30	0.70	3.30	3.70	4.00
Diluted EPS	0.30	0.70	3.30	3.70	4.00
Basic Average Shares	2,394,700	2,456,700	3,059,800	3,059,800	3,059,800
Diluted Average Shares	2,394,700	2,456,700	3,059,800	3,059,800	3,059,800
EBITDA	82,497,000	85,322,000	90,425,000	99,263,000	94,411,000



Компанийн мэдээлэл

Хувьцааны код:	CHU
Бирж:	NYSE
Салбар:	Технологи
Зах зээлийн үнэлгээ (\$ тэрбум)	200.11B
Хаалтын ханш:	6.30
Target Price:	10.60
52 weeks high/low:	5.08-12.05
Dividend yield	3.04%
Үнэ ашгийн харьцаа (P/E)	13.10

1 жилийн хувьцааны ханш



Үзүүлэлт	2020 YTD	2019
Ханшийн өөрчлөлт	-33.2%	-9.1%
HSI индекс	-14.0%	-12.5%
Салбарын индекс	-4.0%	7.8%
Div Yield	2.7%	1.5%

Шинжээчдийн таамаг ханш (HKD)

Buy	20
Hold	5
Sell	1
Current Price (USD)	6.30
Target Price (USD)	7.25

